

ОЮУНЫ САН ХӨМРӨГТ КАЗАХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Б.Алтангүл доктор

МУИС, ГХСС, Франц-Роман судлалын тэнхмийн эрхлэгч

Түлхүүр үг: казах эмэгтэйчүүд, нийгэм, оюуны сан хөмрөг

Казах эмэгтэйчүүд өрх гэрийн тэргүүний тулах нэг багана, үр хүүхдийнхээ асралт ээж, айл гэрийг холбогч гүүр, аав ээжийн асралт охин, ар гэрийн найдвартай хамгаалагч, найз нөхдийн зөвлөгч төдийгүй нийгмийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулахаар үеийн үед хичээн зүтгэсээр ирсэн билээ.

Казах эмэгтэйчүүд Монгол улсад Хувьсгал ялснаас хойш эрчүүдтэй мөр зэрэгцэн улс орныхоо хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулан, хойч үеийнхэндээ мэдлэг туршлагаа өвлүүлэх талаар байнга анхаарал хандуулж ирсэн нь түүхэн баримтаас харагдаж байна.

Монгол улсын 21 аймгийн 145 суманд казах иргэд доорхи байдлаар тархан амьдарч байна¹³⁰.



Монгол улсад нийт 141 539 казах иргэн амьдарч байгаагийн 70 431 буюу 49.8% эрэгтэйчүүд, 71 108 буюу 50.2 8%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Улаанбаатар хотод Налайх, Багануур дүүргийг оролцуулан 10 167 казах иргэн байгаа бөгөөд 5090 эрэгтэй, 5077 эмэгтэй хүн байна гэсэн статистик үзүүлэлт

¹³⁰ Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол улсын харьяат казах иргэдийн тоо (2008 оны 10-р сарын 1-ний байдлаар)

гарчээ. Баян-Өлгий, Улаанбаатар хотоос өөр аймаг, сумдад 27 176 хүн амьдарч байгаагаас 13 379 эрэгтэй, 13 827 эмэгтэй тус тус оршин сууж байна.

Эх хэлний орчиноос хол оршин сууж байгаа казах иргэдийн хувьд үр хүүхэддээ эх хэл, соёл, зан заншилаа хадгалж үлдээх, хэл соёл нэгтэнтэйгээ гэр бүл болгох нь тулгамдсан асуудлын нэг бөгөөд эмэгтэйчүүд, эхчүүд энэ тал дээр зохих хувь нэмрээ оруулж ирсэн, одоо ч энэ үүргээ умартаагүй байна.

Оюуны сан хөмрөгт оруулсан казах эмэгтэйчүүдийн үүргийн тухай өгүүлэхэд тухайн орны нийгэм улс төр, аж ахуй, амьжиргааны түвшинг ярихгүй байхын аргагүй юм. Иймд 1940 оноос 1990 оны үеийн, 1990 оноос хойшхи үеийн казах эмэгтэйчүүдийн үүрэг хэмээх хоёр үед ангилан авч үзвэл үнэнд илүү ойртох байх.

1. 1940 оноос 1990 оны үеийн Монголын казах эмэгтэйчүүд

Монголд ирж суурьшсан Казахуудын түүхийг авч үзэхэд 1940 он хүртэл өөрийн гэсэн нэгдсэн аймаггүй байлаа. Гэхдээ Ховд аймгийн харъяанд байх үед ч гэсэн казах эмэгтэйчүүд тухайн үеийнхээ монгол эмэгтэйчүүдтэй мөр нийлүүлэн, социализмын хөгжилт цэцэглэлтэнд зохих хувь нэмрээ оруулж иржээ. Хэдийгээр эмэгтэй хүнийг үс нь урт, ухаан нь богино гэж үздэг үзэл давамгайлдаг байсан хэдий ч эрчүүдийн өмөг түшиг, ар гэрийн найдвартай гол багана байсан юм. Монгол хэл мэдэхгүй хэдий ч сурахыг тэмүүлэн анхны оёдлын цех Баян-Өлгий аймагт байгуулагдахад эмэгтэйчүүд олноороо ирж ажиллан Баян-Өлгий аймгийн хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулж байжээ. Аймаг байгуулагдан төвхнөх болсон үеэс Багш нарын түр сургууль байгуулан Казакстанаас 12 багш, Гэгээрлийн яамнаас Д.Цэвэгмэд¹³¹ нар очиж ажиллаж байжээ. Хувьсгалт намаас зохион байгуулсан төрөл бүрийн сургалтанд казах эмэгтэйчүүд хамрагдсанаас гадна гэрт үлдсэн нэгэндээ нөлөөлөн, яваандаа Монголын казах эмэгтэйчүүдийн сэхээтний бүлэг бүрэлдэн бий болоход нөлөөлсөн байна.

Энэхүү өгүүлэлдээ анхны сэхээтэн казах эмэгтэйчүүд, тэр тусмаа эмч, багш, сэтгүүлч, зохиолч гэх зэрэг оюуны салбарт амжилт гарган олны танил болсон эмэгтэйчүүдийн тухайд та бүхэнд танилцуулахыг зорьсон билээ. Дашрамд хэлэхэд энэ талын судалгаа хомс, тоо баримт дутмаг байсан тул ерөнхийдөө гол төлөөлөл болгон ажил хөдөлмөр, авьяас билгээрээ тэргүүлсэн эмэгтэйчүүдийг товчлон танилцуулж буй тул бүх сэхээтэн, боловсролтой казах эмэгтэйчүүдийг хамруулж чадсангүй гэдгээ дурьдах нь зүйтэй болов уу. Мөн хүний нэрийг буруу ташаа оруулж бичсэн бол та бүхнээс хүлцэл өчих нь зүйтэй билээ.

1.1 Боловсролын салбарын анхдагч шилдэгүүд

Алс бөглөө Монголын баруун зүгт орших Баян-Өлгий аймгийн хувьд Ардын хувьсгалаас өмнө ард түмэн нь бичиг үсэггүй байлаа. Бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгахын тулд багш нарыг бэлтгэх сургуулийг тухайн үеийн Чандмань- Уул

¹³¹ Баян-Өлгий аймгийн нэвтэрхий толь, УБ, 2010, 35-р тал.

аймгийн Алтайханы хошуу (Алтанцөгц)-нд “Танхим” нэртэй анхны бага сургуулийг 1920 онд 24 хүүхэдтэй байгуулж байсан түүхтэй ажээ¹³².

Энэ үед нам засгаас үндэсний цөөнхийг бичиг үсэгт сургах, гэгээрүүлэх, шинэ цагийн соёлыг түгээх, үндэсний боловсон хүчин, сэхээтнийг бэлтгэсэн байна.

1940 оны 8 дугаар сард Ардын боловсролын яамны тушаалаар бага ангийн багш нарыг бэлтгэх 2 жилийн сургуулийг 60 хүний бүрэлдэхүүнтэй аймгийн төвд хичээллүүлэх, энэ сургууль болон бусад бага сургуулиудад багшлах 12 багшийг Зөвлөлт Казахстанас урьж ирүүлэх, эдгээр ажлыг газар дээр нь зохион байгуулан хэрэгжүүлэхэд туслах ажлаар яамнаас Д.Цэвэгмэдийг мэргэжилтэний хамт ирүүлэн ажиллуулах зэрэг арга хэмжээ авчээ. 1942 оноос сургууль төгсөгчид сумдын сургуулиудад хуваарилагдан багшлахын хамт иргэдийг бичиг үсэгт сургах бүлгэм, дугуйлангуудад давхар ажиллаж байв.

Иргэдийг бичиг үсэгт сургахад 1941 оны 11 сард аймагт анх казах хэвлэлийн тасаг байгуулан, казах хэл дээр сонин хэвлэдэг болсон зэрэг нэлээд олон арга хэмжээ авчээ¹³³.

Намын дээд сургуулийн дэргэд 1945 онд казах хэл дээр хичээллэдэг тусгай ангийг шинээр нээн М.Зукар, Б.Шөрке, С.Манар, М.Катила, Ламия зэрэг 20 гаруй эмэгтэйчүүдийг суралцуулсан нь казах эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхийг дээшлүүлэх, гэгээрүүлэх алхам болжээ. МУИС-д 1947 оноос 7 дугаар анги төгссөн казах залуучууд элсэн орж эмч, багш мэргэжлээр суралцаж эхэлсэн байна¹³⁴.

Одоо Баян-Өлгий аймагт 2008 оны байдлаар 42 Ерөнхий боловсролын сургуульд 1274 багш ажиллаж байна гэсэн тооцоо гарчээ¹³⁵.

Ингээд анхны багш нарын нэг болох Ж.Хазира, М.Хатира нарын тухайд товчхон авч дурдая.

Анхны сэхээтэн эмэгтэй, багш Ж.Хазира 1944 онд намын залуу боловсон хүчнийг бэлтгэх сургуульд Уазира, Ламия нартай хамт ирж суралцжээ. 1947 онд уг сургуулиа амжилттай дүүргэн хэвлэх үйлдвэрт редакторын ажилд орсон байна. Казахстан улс руу боловсрол эзэмшихээр явсан анхны 12 сурагчийн нэг болж орох хувь тохион 1955 онд амжилттай дүүргэн ирж 10 жилийн 1-р сургуульд 15 жил газар зүйн багшаар ажиллаж байгаад нөхөр Шахерханыг даган Улаанбаатар хотод ирж суурьшан 10 жилийн 33-р сургуульд багшаар олон жил үр бүтээлтэй ажиллажээ. Боловсролын тэргүүний ажилтан бөгөөд үе тэнгийнхнээ болон залуу үеийг орчин үеийн соёл боловсролыг олж мэдэхэд биеэрээ үлгэрлэж яваа эмэгтэй юм.

Казахстанд боловсрол эзэмшихээр явсан 12 эмэгтэйн нэгэнд М.Хатира оржээ. Улаанбаатар хотод ирж багшийн сургуульд амжилттай сурсаны дараа Казахстаны алдарт зохиолч Абайн нэрэмжит багшийн сургуульд суралцан хими-биологийн багш мэргэжлээр 1955 онд төгсчээ. Ирээд монгол сургалттай 10 жилийн 2-р сургуульд мэргэжлээрээ болон орос хэлний багшаар ажиллаж байгаад 1-р 10-

¹³² Б. Монголхүү, Цаст Алтайн чуулган, УБ, 2009

¹³³ Баян-Өлгий аймгийн нэвтэрхий толь, УБ, 2010, 37-р тал.

¹³⁴ Баян-Өлгий аймгийн нэвтэрхий толь, УБ, 2010, 42-р тал.

¹³⁵ Баян-Өлгий аймгийн нийгэм, эдийн засгийн статистикийн хураангуй, 2009.

н жилд 36 жил багшилсан байна. М.Хатира гуай залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч, 50, 60, 70 жилийн ойн медальтай.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд анхны захирал эмэгтэй бол Б.Бижамила юм. 1942 онд Баян-Өлгий аймагт байгуулагдсан багш нарыг бэлтгэх сургуульд сурч Баяннуур сумын бага сургуульд очиж ажилласан байна. Тасралтгүй 23 жил тэндээ түүх газарзүйн хичээл зааж залуу үеийг сурган хүмүүжүүлж байгаад Өлгий хотод ирж шинэ нээгдсэн 8 жилийн сургуулийн захирлаар томилогджээ. Шинэ сургуулийг хөл дээр нь босгох гэж 10 жил тасралтгүй зүтгэн “тэргүүний багш”, “шилдэг зохион байгуулагч” гэх алдарыг хүртсэн хүн билээ.

Эдгээр анхны багш, захирал нартай мөр зэрэгцэн ажиллаж байсан Б.Шөрке, К.Батиш, М.Зукар, Замеш, К.Гүлсин, Х.Элеухан, А.Жинкей, Хаман, Хания, К.Шармен, Р.Шөген, Манар, Д.Кулымхан, Серенай, Табарак, Займке, Ө.Бишан, Бүршинбас, К.Кулияш, А.Кадыхан, Кинашхан, Х.Маги, С.Газиза, Ж.Ниса, Ш.Күляш, К.Күлдан, К.Когай, М.Динашхан, Т.Зулмира, Д.Кибадат, Аралхан, Б.Ардак, К.Алтангүл нарыг дурьдахгүй өнгөрч болохгүй мэт.

Энэ ялдамд сэхээтэн эмэгтэйн нэг М. Зукар багшийн тухайд ярих нь зүйтэй болов уу. М.Зукар багш анхны түүхийн багш эмэгтэй. Энэ эмэгтэй биеийн тамирын ач холбогдлыг ард түмэнд ухуулан таниулан талаар онцгойлон үүрэг гүйцэтгэж өөрөө ч спортын олон төрлөөр хичээллэж байв. М.Зукар багш оролдлогоо бичиг үсэгт тайлан улмаар 1940 онд бага сургуульд орж суралцан 1944 онд аймгийн төвийн 7 жилийн бүрэн бус сургуулийг төгссөн. 1944-1945 онд Толбо сумын бага сургуульд багшаар ажиллаж байгаад өөрийн хүсэлтээр намын боловсон хүчний дээд сургуульд элсэж 4 жил суралцаад 1948 онд төгссөн ба 1954 онд МУИС-ийн түүхийн ангид орж суралцаад түүхийн багш мэргэжлээр 1958 онд төгссөн. М.Зукар нь ардын боловсрол, эмэгтэйчүүд, олон нийтийн байгууллагууд болон нам төрийн байгууллагуудад нийтдээ 42 жил тасралтгүй идэвх зүтгэлтэй, үр бүтээлтэй ажиллаж байгаад 1989 онд өндөр насны тэтгэвэрт гарсан юм. Тэр бээр Монголын эмэгтэйчүүдийн зөвлөлд зааварлагч, С.Янжмаа гуайн нарийн бичгийн даргын албыг хашиж явсан түүхэн эмэгтэй билээ.

Мөн Х.Маги гуай Багшийн сургууль төгссөний дараа нийгмийн ажилд олон жил зүтгэсэн бөгөөд залуучуудыг сурган хүмүүжүүлэхэд ухамсарт амьдралаа зориулсан нэгэн. Үйлдвэрийн ажилчдыг хөдөө илгээлтээр явуулах, хотыг цэцэрлэгжүүлэх, Баян-Өлгий аймагт өнчин хүүхдийг асран хамгаалах сургууль, тэдэнд зориулсан сурах бичиг хэвлүүлэх, Ислам шашинтай орнуудад аялалыг санаачлан зохион байгуулагч нэгэн юм.

Энд мөн Д.Раягийн багшийн тухай цухас дурьдахад таатай байна. Тэрбээр 1979 оноос хойш УБ хотын өнчин хүүхдийн асрах төвд ажиллаж байгаа бөгөөд 1988 онд Афганистанаас ирсэн 27 өнчин хүүхдийг асрахад гүйцэтгэсэн үүргийг нь үнэлэн Афганистаны “Найрамдлын одон”- оор 1995 онд шагнагдсан байна.

Өнөө үед Баян-Өлгий аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллагсадын ихэнхи хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ард түмний хүүхдийг гэгээрүүлэх үйлсэд эмэгтэйчүүд гол үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд С.Түрлен, Б.Бибигүл, Р.Сагай, М.Инжү, Алмагүл, Күлпаран, Индира зэрэг эмэгтэйчүүд олон жил ерөнхий боловсролын сургуулийн захирлын албыг, И.Асемхан, Б.Гүлнар,

З.Сахым, К.Съезд, К.Гүлгайым, С.Күлай, З.Света, А.Гүлжан, Ш.Минейхан нар олон жил цэцэрлэгийн эрхлэгчээр үр бүтээлтэй ажиллаж байна.

1.2 Эрүүл мэндийн салбарын анхдагч, шилдэгүүд

Хувьсгалын дараахь он жилүүдэд хүн амыг эрүүлжүүлэх, элдэв халдварт өвчнөөс сэргийлэх, аймаг сумдын төвд их бага эмчийн салбар байгуулах ажил зохион байгуулжээ.

Баян-Өлгий аймагт орчин үеийн анагаах ухааны эмнэлгийн анагаах ухааны эмнэлгийн суурь аймаг байгуулагдсан 1940 оноос эхэлсэн байна. 6 суманд бага эмчийн салбартай байж байгаад 1954 онд Баян-Өлгий аймгийн төвд нэгдсэн эмнэлэгтэй, сумдад их эмчийн 2 салбар, 18 бага эмчийн салбартай болсон байв¹³⁶.

1945 онд Баян-Өлгий аймгаас 12 охидыг Казахстаны Алма-Ата хотод хүний эмчийн техникумд суралцахаар явуулахад Ө.Шура, А.Тоня нар байв. 1953 онд буцан ирж МУИС-ийн хүн эмнэлгийн салбарыг Ө.Шура, А.Тоня нар үргэлжлүүлэн сурж 1954 онд төгсжээ. Тэгэхээр Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн анхны их эмч энэ хоёр эмэгтэй болж байгаа юм. Тэднийг нутагтаа буцаж ирэхэд А.Тоня-г аймгийн эрүүл мэндийн салбарын дарга, Ө.Шураг нэгдсэн эмнэлэгт эмчээр томилжээ. Ийнхүү их эмч Ө.Шура бага эмч, лаборант, оёдолчин, 6 сувилагч нартай хамтран 30 ортой эмнэлгийг хөл дээр нь босгон, ард түмнийхээ эрүүл мэндийн манаанд гарчээ. Ө.Шура 1956 онд их эмч Ж.Уатхантай хамтарч анхны хагалгааг хийж байжээ. Ө.Шура эмч халдвартын чиглэлээр нарийн мэргэжил эзэмшсэн манай орны анхны эмч нарын нэг бөгөөд 1959 онд аймгийн сүрьегийн диспансарыг байгуулж эрхлэгчээр нь ажилласан байна. Тэрбээр “Алтан гадас” одон, ойн медалиуд болон эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнагджээ. А.Тоня аймгийн эрүүлийг хамгаалах хэлтсийн анхны эмэгтэй дарга юм.

Эрүүл мэндийн салбарт олон жил удирдах ажил хийсэн Ж.Марзияг онцлон дурьдахгүй байж болохгүй билээ. Тэрбээр удирдах ажил хийн олонд танигдсан эмэгтэй билээ.

Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвийн радиологийн их эмч А.Мутай казах эмэгтэйчүүдээс төрсөн анхных нь юм.

Казах эмэгтэйчүүдээс уламжлалт анагаах ухаан, зүү төөнүүр, бариа заслаар анхдагч нь Е.Пашка эгч билээ.

Улаанбаатар хотод амьдардаг, үе залгамжилсан, залуугаараа эмнэлгийн удирдах хариуцлагатай ажил эрхэлсэн казах эмэгтэйн нэг яах аргагүй А.Бахытжан гэдгийг онцлон хэлэхэд таатай байна.

Баян-Өлгий аймгийн анхны эмч нар Ө.Шура, А.Тоня нарын халааг Х.Уазира, Х.Бултихан, Хиналган, Ш.Хадиша, Н.Шарипа, М.Шайза, Ш.Жанылгаан, Ч.Риза, М.Тамара, Ж.Марзия, Х.Хапиза, Х.Шаги, К.Батиа, Мүшелбай, Өнерхан, С.Татьяна, Х.Сайтхан, Кабай, Е.Дора, Ө.Гүлнар, Л.Сара, Ч.Кенжехан,

¹³⁶ Б. Монголхүү, Цаст Алтайн чуулган, УБ, 2009

Л.Карлыгаш, Лазихан, А.Мүтай, Б.Ратай, П.Пашка, А.Бахытжан, Ж.Тилек, К.Анаргүл, Б.Шолпан, Р.Баян, С.Еркегүл, М.Жанар гэх мэт үе үеийн олон эмч үргэлжлүүлэн энэ салбарын ахмад үеийн халааг дунд, залуу үе уламжлан авч байна.

Одоо Баян-Өлгий аймагт нарийн мэргэжлийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг, халамжийн эмнэлэг, хувийн эмнэлэг, байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах газар, Рашаан сувилал, эм хангамжийн байгууллага, сум болон багийн эмнэлэг зэрэг эрүүл мэндийн 52 нэгж байгууллагад 142 их эмч, 19 эм зүйч, 349 дунд мэргэжилтэн, 135 туслах ажилтан ажиллаж байна. Анагаах ухааны магистр эмч 16, тэргүүлэх зэрэгтэй эмч 4, клиникийн профессор 9, ахлах зэрэгтэй сувилагч 9 ажиллаж байна. Аймаг байгуулагдаж байсан үеийг бодоход их, бага эмч болон орны хүрэлцээ, эрүүл мэндийн хүртээмж харьцангуй сайжирч, үндэсний боловсон хүчний нэгэн том арми бүрэлдэн бий болжээ.

Баян-Өлгий аймгийн эрүүл мэндийн хэлтэс, газрын даргаар А.Тоня (1954-1955), Ж.Марзия (1980- 1987), А.Гүлжан (1996- 2000), А.Күлаза 2008- 2010 он хүртэл ажиллаж байна.

1.3 Соёл урлагийн шилдэгүүд

Шинэ цагийн соёр урлагийн үүд мөн аймаг байгуулагдсан түүхэн үе 1940-ээд онтой холбогдож буй юм. 1944 онд гэхэд аймгийн төвд клуб, номын сан, нүүдлийн улаан гэр, кино ший гаргах газартай, 12 сум өөрийн гэсэн улаан булантай болж, 73 гаруй уран сайханч ажиллаж байжээ. 1956 оны 3-р сарын 15-нд хөгжимт драмын театр нээлтээ хийсэн нь мэргэжлийн боловсон хүчин ажиллах нөхцөл, бололцоог хангаж өгчээ¹³⁷.

Анхны мэргэжлийн жүжигчин Б.Хайжамал гуай юм. 1938-1941 онд Улаанбаатар хотод уран сайхны сургуульд суралцаж жүжигчний мэргэжил эзэмшсэн байна. 1941-1953 онд аймгийн намын хорооны эмэгтэйчүүдийн хэлтэст зааварлагч, хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байгаад 1956 онд аймгийн хөгжимт драмын театр байгуулагдахад урлагийн ажилдаа эргэн орж 1966-1974 онд театрын даргаар ажиллав. Тэрбээр 1948 оны МХЗЭ-ийн 11-р их хурал, 1954 онд МАХН-ын 12-р их хурал, 1958 онд Австри улсын Вена хотод болсон Дэлхийн ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны 4-р хуралд оролцсон байна. Ажил үйлсээрээ олон түмний итгэл хүлээж БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатаар сонгогдож байв. 1960 онд БНМАУ-ын гавъяат жүжигчин цол хүртжээ.

Тухайн үеийн урлагийн алтан тайзнаа “казахын алтан гургалдай” хэмээн нэрлэгдэж байсан эрхэм хүний нэг бол дуучин Ж. Хаду юм. Тэрбээр 1959 онд аймгийн хөгжим бүжгийн театрын хор-драмын ангид элсэн суралцаж, авьяас билгээрээ дуучин болох замналаа эхэлсэн байна. Ж. Каду 40 жилийн хугацаанд ардын болон сонгодог дуунуудыг амилуулан, ард олныг соёл урлагийн тансаг байдлыг мэдрүүлэхэд ихээхэн хувь нэмрээ оруулсан эмэгтэйчүүдийн нэг билээ. Тэрбээр гайхамшигт казах дууг Монгол орны өнцөг булан бүрт хүргэснээс гадна

¹³⁷ Б. Монголхүү, Цаст Алтайн чуулган, УБ, 2009

1962 онд Финляндын Хельсинк хотод болсон оюутан залуусын 8-р фестиваль, 1968 оны Болгарт болсон фестиваль, мөн Румын, Польш, ЗХУ-ын ихэнхи хотоор явж “Казах вальс”, “Булбул” зэрэг дуугаараа олны танил болсон эмэгтэй юм. Түүний хөдөлмөрийг өндрөөр үнэлж 1975 онд БНМАУ-ын гавъяат жүжигчин цол хүртээжээ.

Соёл урлагийн салбарт шинэ боловсон хүчин төрж, Хөгжим бүжгийн дунд сургууль, Соёлын дунд, дээд сургуулийг төгсөн, хэдийгээр Баян-Өлгийн аймагт ажиллахгүй байгаа ч хот газар амьдарч буй казахуудад соёлын үрийг эмэгтэй дуучид тарьж явна. Соёлын тэргүүний ажилтан К.Алтынгүл, Х.Айгүл, М.Үмытхан, Б.Меруеш, ардын тэргүүний авьяастан, дуучин С.Шуга, М.Толхын нарыг дурьдах нь зүйтэй юм.

1.4 Бусад салбарын шилдэгүүд

Эрүүл мэнд, боловсрол, урлагийн салбараас гадна биеийн тамир, бусад салбарт төрсөн анхны казах эмэгтэйчүүдийн тухайд цухас өгүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Х.Рамазан Монголын казах эмэгтэйчүүд дотроос анх инженер-технологич мэргэжил эзэмшиж, төрийн яамны хэлтсийн даргын албыг хашиж явсан эмэгтэйн нэг. ЗСБНХУ-ын Ленинград хотод Зөвлөлтийн худалдааны дээд сургуульд /ЛИСТ/ суралцсан байна. Тэрбээр “худалдааны тэргүүний ажилтан” ажээ. Энэхүү инженерийн араас А.Бакен, К. Касиран, Г.Күлжамиш, Д.Роза, Ханипа, Б.Алтыншаш зэрэг олон чиглэлийн эмэгтэй инженерүүд төрөн гарчээ. Анхны математикч, инженер-конструктор казах эмэгтэй бол К.Хасиран юм.

Х.Хания хөнгөн үйлдвэрийн машин аппаратурын механик инженер бөгөөд Ээрмэлийн үйлдвэрийн гүйцэтгэх захирлын албыг хашиж буй цөөхөн эмэгтэйчүүдийн нэг билээ.

Казах эмэгтэйчүүд дотроос зоотехникч, малын эмч, агрономч нар төрсөний дотор К.Гайны, Айемхан, Жамилаш, Жилкей нар анхдагчид байсан юм.

Р.Алданыш Монголын казах эмэгтэй анхны тамирчин төдийгүй Монгол улсаас Олимпийн тэмцээнд оролцсон анхны эмэгтэй тамирчин юм. Тэрбээр биеийн тамир, спортын салбарт төрсөн анхны казах хүн. Р.Алданыш 10 жилийн 18-р сургуульд суралцаж байхдаа гүйлтийн тэмцээнд урьдаа хүн оруулдаггүй байж. Үүнийг ажигласан хөнгөн атлетикийн дасгалжуулагч Ү.Найдан хөнгөн атлетикийн дугуйланд оруулж дасгалжуулах болсон байна. 1964 онд Токиод болсон Олимпид анхны эмэгтэй тамирчин болж оролцсон бөгөөд 30 гаруй медалиар энгэрээ мялаасан нэгэн байна. 1964-1972 онд Улсын шигшээ багт гүйлтийн тамирчин байхдаа 200, 400 800, 4x200, 4x400 метрийн гүйлтээр улсын рекорд амжилтыг 30 гаруй удаа тогтоосноор барахгүй 800 метрийн амжилтыг нь одоо ч гэсэн эвдээгүй байна¹³⁸.

¹³⁸ Б. Монголхүү, Цаст Алтайн чуулган, УБ, 2009

1947 оноос Монголын Үндэсний радиогоос долоо хоногт нэг удаа казах хэл дээр тогтмол нэвтрүүлэг явуулахаар тогтжээ. 1960 онд Монголын радиогийн казах редакцийн нэвтрүүлэгчээр С.Займке, А.Хавылахат нар ажилласан байна. 1965 онд Баян-Өлгий аймагт радио редакци болон радио өргөн нэвтрүүлгийн станци ашиглалтанд ороход анхны нэвтрүүлэгчээр Х.Күлдан, З.Гүлдари, А.Хавылахат нар ажиллан, өдөр бүр 30 минутын нэвтрүүлэг цацан ард түмнийг мэдээллээр хангаж байжээ.

Аймгийн анхны хуульч эмэгтэй Дикейн Комосия юм. Тэрээр 1967 оны үед Монгол улсын их сургуулийг хуульч мэргэжилээр дүүргээд хөдөлмөрийн гараагаа аймгийн хууль, хяналтын байгууллагаас эхэлсэн байна.

2. 1990 оноос хойшхи эмэгтэйчүүд

Монгол орны нийгэм улс төрийн амьдралд бүхэлдээ өөрчлөлт орж, гадаад ертөнцөд нээлттэй болсоноор гадаад, дотоодод сурч боловсрох бололцоо бүх хүнд бүрэн нээгдсэн юм. Аймаг байгуулагдсан үеийн эмэгтэйчүүдтэй харьцуулахад энэ үеийн эмэгтэйчүүдэд сурч боловсрох, мэдлэгээ турших, гадаадын олон орноор явж туршлага судлах зэрэг нааштай үзүүлэлтүүд гарсан юм. Шинэ үеийн боловсон хүчний тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь асар их болж, нийгэм, улс төр, эдийн засаг гээд бүхий л салбарт эмэгтэйчүүд тэргүүлэх боллоо.

1940- 1990 оны үед амьдарч байсан эмэгтэйчүүдийн хувьд шинэ аймгийг төвхнүүлэх, соёлын үрийг тарих, гэр бүлээ асран халамжлах, социалист Монгол улсын хөгжил цэцэглэлтэнд хувь нэмэр оруулахаас гадна өөрсдийгээ боловсруулах зэрэгт түлхүү анхаарч ирсэн харагдана. Энэ үед сурч боловсорсон олон эмэгтэй байсан хэдий ч эрдмийн зэрэг хамгаалах боломж муутай, тэгээд ч хамгаалах систем төвөгтэй байсан тул бараг эмэгтэй эрдэмтэн төрж гараагүй байна. 1990 оноос хойш 20 гаруй казах эмэгтэй эрдэмтэн төрөн гарсан нь энэ үеийн онцлог гэж хэлж болохоор байгаа юм.

Анхны эрдэмтэд Монгол улсад 1950-иад оноос эхлэн төрсөн бөгөөд анхны казах эрдэмтэн Ө.Хамбар 1961 онд эдийн засгийн ухааны доктор (одоогийнхоор Sc.D) байжээ. Эмэгтэй эрдэмтдийн хувьд Х.Анаргүл 1988 онд Ph.D, 1997 онд Sc.D зэргийг тус тус хамгаалжээ.

Монгол улсад эрдмийн зэрэг хамгаалсан казах эмэгтэйчүүдийг доор хүснэгтээр харуулав.

№	Овог нэр	Он	Чиглэл	Сэдэв
1	Х.Анаргүл	1988	Анагаах (Ph.D)	“Мухар олгойн хурц өрөвсөлт өвчний шалтгаан, оношлогоо, эмчилгээний асуудал”
		1997	(Sc.D)	Хэвлийн хөндийн гялтангийн түгээмэл идээт өрөвсөлт өвчний оношлогоо, эмчилгээ.
2	И.Ризагүл	1992	Биологи	Хүн ба амьтадын нянгийн халдварт ба халдварлаж болзошгүй өвчний изолятын

				биологийн ба молекулаас үүдэлтэй шинж чанар
3	Д.Лиза	1994	Хэл бичиг	Отражение мироощущения в характере народов: русские и монголы
4	С.Гүлгайша	1996	Хэл бичиг	Казах-Монгол хэлний газрын нэрийн зэрэгцүүлэл
5	Н.Гүлнар	1998	Философи	Соёлуудын харилцан нөлөөлөл ба хөгжлийн хүчин зүйлс
6	М.Озила	1998	Урлаг судлал	Монголын казахуудын уламжлалт дууны соёл
7	Р.Баян	1999	Анагаах	Иерсонозын клиник-эпидемиологийн тодорхойлолт
8	К.Есенгүл	2001	Хэл бичиг	Монголын казах уран зохиолын үргэлжилсэн үгийн төрөл зүйлийн хөгжил, төлөвшил
9	Ш.Унзила	2001	Хууль зүй	1640 оны Монгол-Ойрадын хуулиуд
10	Ч.Гүлнар	2004	Хэл бичиг	Казах хэлнээс монгол, орос хэлэнд орсон үгийн онцлог
11	Б.Алтангүл	2004	Хэл бичиг	Францын уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршлага
12	Д.Саулегүл	2004	Сурган хүмүүжүүлэх	Их дээд сургуулийн боловсролын эдийн засаг
13	Б.Бахытгүл	2006	Хэл шинжлэл	Монголын казахуудын хэл: нийгэм, хэл зүйн онцлог
14	С.Жанбота	2006	Хэл бичиг	Яруу найрагч Байбаатарын Иماشханы уянгын яруу найргийн онцлог, ур чадварын асуудалд
15	Н.Лиза	2008	Боловсрол судлал	Монголын казах сургуулиуд бүрэлдэн хөгжсөн нь./1927-1995 он/
16	Х.Женисгүл	2008	Хууль зүй	Монгол Улсын хууль тогтоомжинд заасан танхайрах үйлдэлийн эрүүгийн эрх зүй болон криминологийн шинж чанар
17	Т.Күлжамиш	2008	Геологи	Ашигт малтмал ордын хэтийн төлөвийг газар зүй мэдээллийн аргаар үнэлэх нь
18	Ж.Хиналган	2008	Хэл бичиг	Монголын казах хэлт уран зохиолын үүсэл хөгжил, төлөвшил
19	А.Булбулгүл	2008	Анагаах	General Herpes in Risk Human Immunodeficiency Virus infected and uninfected women in US
20	Б.Бибигүл		Хэл шинжлэл	

Монгол улсад бүрэн бус мэдээгээр 30 гаруй эрэгтэй, 1 эмэгтэй шинжлэх ухааны (Sc.D) казах доктор, 200 орчим эрэгтэй казах доктор (Ph.D) байгаагаас 20 гаруй эмэгтэй доктор байгаа нь чамлахаар тоо биш юм.

Х.Анаргүл анхны казах эрдэмтэн эмэгтэйдээс гадна шинжлэх ухааны доктор болсон анхдагч болгоны шавийг татсан эмэгтэй гэж хэлж болно. Тэрбээр 1974 онд Анагаах ухааны дээд сургуульд орж 1980 онд төгсжээ. 1980-1982 оны үед Булган аймгийн Хишиг-Өндөр сум дундын эмнэлэгт мэс заслын эмчээр хоёр жил ажиллан, 1982 оноос Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны эмнэлэгт мэс заслын эмч, зөвлөх эмч, тасгийн эрхлэгчээр тус тус ажилласан байна. 1988 онд ЗХУ-ын С.М.Кировын нэрэмжит Цэргийн хүн эмнэлгийн Академийн Цэргийн хээрийн мэс заслын танхимд “Мухар олгойн хурц өрөвсөлт өвчний шалтгаан, оношлогоо, эмчилгээний асуудал” сэдвээр Анагаах ухааны дэд эрдэмтний зэрэг, 1997 онд Оросын Холбооны Улсад Цэргийн хүн эмнэлгийн ерөнхий мэс заслын танхимд “Хэвлийн хөндийн гялтангийн түгээмэл идээт өрөвсөлт өвчний оношлогоо, эмчилгээ” гэсэн сэдэвт бүтээлээр Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан байна. Тэрбээр “Хүндэт хилийн харуул”, “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан”, “Алтан гадас” одонт, хүний “Гавьяат эмч” хурандаа эмэгтэй юм.

Энэ дашрамд анхны хөгжим судлаач казах эмэгтэйн тухайд цөөн хэдэн үг дурьдах нь зүйтэй гэж бодож байна. М. Озила 1974- 1980 онд Казахстаны Алма-Ата хотын Хөгжмийн дээд сургуульд орж хөгжим судлаачийн мэргэжлээр төгссөн байна. 1998 онд Казахстаны Үндэсний шинжлэх ухааны академийн уран зохиол, урлагийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн хөгжим судлалын салбарт “Монголын казахуудын уламжлалт ардын дуу” сэдвээр урлаг судлалын докторын зэрэг (Ph.D) хамгаалжээ.

Геологийн салбарын анхны эмэгтэй доктор Т.Гүлжамиш 1983 онд Политехникийн дээд сургуулийг төгсөн “Монгол- Болгар металл”-д инженер-геолог гэх зэрэг алба хашиж 2008 онд геологийн салбарт анхны казах эмэгтэй доктор болжээ.

Философийн ухаанаар анхны эмэгтэй доктор Н.Гүлнар, хууль зүйн ухаанаар Ш.Унзила, Франц хэлний чиглэлээр Б.Алтангүл, халдвар тархвар судлалаар Р.Баян, Америкт анх хамгаалсан А.Булбулгүл нараар бид бахархаж байна.

Казах эрдэмтэн эмэгтэйчүүдээс төрсөн анхны профессор бол Ш.Гүлнар юм.

Эмэгтэй судлаачдыг сэдвийг ажиглахад Монгол дахь казахуудын түүх соёл, зан заншил, боловсрол, уран зохиолын хөгжил, ардын дуу гээд Монгол дахь казах судлалын үндсийг тавьж, эрэгтэй судлаачидтай мөр зэрэгцэн ажиллаж буй нь харагдаж байна.

Монголын казах эмэгтэйчүүд эрчүүдийн адил бүх салбарт боловсрол эзэмшин, улсынхаа хөгжил цэцэглэлтэнд хувь нэмэр оруулахын зэрэгцээ, эх хүн, ээж хүнийхээ үүргийг умарталгүй үр хүүхдээ асран хүмүүжүүлж, нийгэмд өөрийн зохих хувь нэмрээ оруулан ажиллаж амьдарч байна.

Ашигласан ном, зохиол

- Арулар жүлдыз, дугаар 1, 1 (2), 1 (6), 1 (13), 2 (3), 2 (6), 2 (10), 3 (7), 3 (11).
- С. Айнагүл, Казахын шилдэг эмэгтэйчүүд, УБ, 2010.
- Баян- Өлгий аймгийн нэвтэрхий толь, УБ, 2010.
- Баян- Өлгий аймгийн нийгэм, эдийн засгийн статистикийн хураангуй, Өлгий, 2009
- Казах үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт, УБ, 2009.
- Н. Марияш, Айналаын арулар (Эрхэм хүндэт эмэгтэйчүүд минь), УБ, 2000.
- Б. Монголхүү, Цаст Алтайн чуулган, УБ, 2009.
- Б. Алтангүл, Монголын Казахууд - илтгэлээс, Франц улс, эрдэм шинжилгээний хурлын илтгэл, 2009.
- Ахмадуудын аман зөвлөгөө (Хадам эцэг, эх К. Рашат, Ш. Жанылгаан нарын аман баримтууд)

Abstract

Kazakh women's contribution to the intellectual property of the culture.

Women of an every country of the world make their own contribution to the development of a family, a policy, a society and a country as well. A non-governmental organization (NGO) "Arular" or "Women" since it's time of foundation pays much attention to the study and research of Kazakh people's life who have moved to Mongolia for residential living upon a time and especially to the role of Kazakh women in a society.

Kazakh women on one hand are a "pillar" of a family head, a mother who takes care of children, a bridge of a family, a daughter who takes care of parents, a reliable protector of a family and an advisor to a friend but on the other hand so far from generation to generation they try their utmost to make their own contribution to the development of a society as well.

We can see from the historical documents that Kazakh women after a victory of the Revolution in Mongolia went side by side with men and made their contribution to the deal of development and prosperity of the country and paid a great attention to the deal of passing down to the next generations their knowledge and experience. Our goal is to show up mainly how do they reach success in the intellectual field as well.

НИЙТЛЭЛИЙН ШААРДЛАГА, СТАНДАРТ

Эрдэмтэд, судлаачид Та бүхнийг **Политологи** сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, илтгэл, шүүмж өгүүлэл зэргээ нийтлүүлэхийг урьж байна. Сэтгүүлийн зөвлөл нь тухайн бүтээлийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлийн дагуу албан ёсоор хүлээн авсны дараа сэтгүүлийн агуулга, зорилгод нийцүүлэн сонгон шалгаруулж нийтлэнэ.

Бүтээлээ ирүүлэхдээ хэвлэмэл 1 хувийг сэтгүүлийн хаягаар, түүнчлэн электрон файлаар sspr@num.edu.mn хаяг руу хавсаргах шаардлагатай.

Бүтээлд тавигдах шаардлага:

- Сэтгүүлд ирүүлэх бүтээл нь урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Бүтээлийн хураангуй нь 150-иас ихгүй үгтэй байх ба монгол, орос, англи хэлний аль нэг дээр байх.
- Бусдын бүтээлээс текст, зураг, график зэргийг ашигласан бол эх сурвалжийг тодорхой дурьдах
- Бүтээлийн өмнө зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй ажил, ажлын газар, бүтээлийн гарчиг зэргийг бичих

Сэтгүүлд нийтлэгдэх бүтээлтэй холбоотой аливаа асуудлыг зохиогч өөрөө хариуцна.

Сэтгүүлийн зөвлөл

2010 онд хэвлүүлсэн сурах бичиг, гарын авлага



ПОЛИТОЛОГИ VII

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ 348 (61)

Улаанбаатар хот,

Залуучуудын өргөн чөлөө

МУИС-ийн хичээлийн II байр

Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль,

Улс төр судлалын тэнхим

Орчин үеийн улс төрийн судалгааны төв

Утас: 7730-7730 (2306, 2324)

Факс: 976-11- 328890

©2011 CCPR

“ПОЛИТОЛОГИ VII

Эрдэм шинжилгээний бичиг

№ 348 (61)

Хэвлэлтэнд 2011 оны 2-р сар

Цаасны хэмжээ 60х90 1/8

Хэвлэлийн хуудас 22,5

Хэвлэсэн тоо 150 ширхэг

МУИС ХҮС-ийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв.